



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: <a href="mailto:Sunjidmaae@audit.gov.mn">Sunjidmaae@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 11 № 39

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА  
Д.БАТТАЙВАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн хүрээнд "Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа-Цахимжилт", "Хууль бидний амьдралд" сэдэвт уралдаан, тэмцээнийг 18 сум, 2 тосгон гэж бүсчлэн 2 үе шаттайгаар зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд гүйцэтгэлээр 2,471,502.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 6.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Бусад асуудал**

Тайлант онд 4 хөтөлбөр, 21 зорилт, 146 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 138 арга хэмжээ бүрэн, 2 арга хэмжээ 30.0 хувь хэрэгжиж, хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс 6 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

822505000103

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,364,215,352.06</b>	<b>2,266,981,128.56</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,364,215,352.06</b>	<b>2,266,981,128.56</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	314,600.00	314,600.00
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>2,363,900,752.06</b>	<b>2,266,666,528.56</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>2,363,900,752.06</b>	<b>2,266,666,528.56</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	2,363,900,752.06	2,266,666,528.56
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,364,215,352.06</b>	<b>2,266,981,128.56</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>95,381,710.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>95,381,710.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	-	<b>95,381,710.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>95,381,710.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	33,181,200.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	62,200,510.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,364,215,352.06</b>	<b>2,171,599,418.56</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,364,215,352.06</b>	<b>2,171,599,418.56</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,364,215,352.06</b>	<b>2,171,599,418.56</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,622,859,330.00	2,364,215,352.06
51220	Тайлант үеийн үр дүн	741,356,022.06	(192,615,933.50)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,364,215,352.06</b>	<b>2,266,981,128.56</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,537,085,000.00</b>	<b>1,499,522,128.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,537,085,000.00</b>	<b>1,499,522,128.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,537,085,000.00</b>	<b>1,499,522,128.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>523,111,000.00</b>	<b>765,289,856.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	523,111,000.00	640,792,056.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	124,497,800.00
120009	Бусад орлого	2,013,974,000.00	734,232,272.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,795,728,977.94</b>	<b>1,692,138,061.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,795,728,977.94</b>	<b>1,692,138,061.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>67,321,580.00</b>	<b>53,831,620.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>67,321,580.00</b>	<b>53,831,620.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,321,580.00	53,831,620.00

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,728,407,397.94</b>	<b>1,638,306,441.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>395,982,388.00</b>	<b>438,013,078.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	395,982,388.00	438,013,078.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,332,425,009.94</b>	<b>1,200,293,363.50</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,332,425,009.94	1,200,293,363.50
213504	Хөрөнгийн	0.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>741,356,022.06</b>	<b>-192,615,933.50</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>741,356,022.06</b>	<b>-192,615,933.50</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,509,728,977.94</b>	<b>2,788,256,351.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,647,033,680.00</b>	<b>1,499,522,128.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,647,033,680.00</b>	<b>1,499,522,128.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,647,033,680.00</b>	<b>1,499,522,128.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	523,111,000.00	640,792,056.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	124,497,800.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,123,922,680.00	734,232,272.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>862,695,297.94</b>	<b>1,288,734,223.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>862,695,297.94</b>	<b>1,288,734,223.50</b>
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	862,695,297.94	1,288,734,223.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>67,321,580.00</b>	<b>39,482,310.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,321,580.00	39,482,310.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,442,407,397.94</b>	<b>2,748,774,041.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,109,982,388.00</b>	<b>1,548,480,678.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,109,982,388.00	1,548,480,678.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,332,425,009.94</b>	<b>1,200,293,363.50</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,332,425,009.94	1,200,293,363.50

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

( төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023-ны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	1,622,859,330.00	1,622,859,330.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,622,859,330.00	1,622,859,330.00
9	Тайлант үеийн үр дүн	-	741,356,022.06	741,356,022.06
10	2024оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,364,215,352.06	2,364,215,352.06
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	2,364,215,352.06	2,364,215,352.06
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,364,215,352.06	2,364,215,352.06
19	Тайлант үеийн үр дүн	-	(192,615,933.50)	(192,615,933.50)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,171,599,418.56	2,171,599,418.56

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,136,504,328.0</b>	<b>1,587,962,988.0</b>	<b>548,541,340.0</b>	74.3
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,136,504,328.0	1,587,962,988.0	548,541,340.0	74.3
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	64,990,000.0	39,482,310.00	25,507,690.0	60.8
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	64,990,000.0	39,482,310.00	25,507,690.0	60.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,990,000.0	39,482,310.00	25,507,690.0	60.8
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,071,514,328.00	1,548,480,678.00	523,033,650.0	74.8
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,071,514,328.0	1,548,480,678.00	523,033,650.0	74.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,071,514,328.0	1,548,480,678.00	523,033,650.0	74.8
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,136,504,328.0</b>	<b>1,587,962,988.00</b>	(334,997,800.0)	115.7
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2,136,504,328.0	937,962,988.00	(334,997,800.0)	115.7

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,000,000.00	530,428,338.00	(198,936,028.0)	130.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,980,000.00	124,497,800.00	(124,497,800.0)	6,387.8
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,484,524,328.00	283,036,850.00	(11,563,972.0)	100.8
<b>37</b>	<b>Бусад эх үүсвэр</b>		650,000,000.0	(650,000,000.0)	
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		650,000,000.0	(650,000,000.0)	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

**Тав.** Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			